


ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БҮСИЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭХ СУДАЛГАА ХИЙХ, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН



ТЭНГИС-ШИШГЭДИЙН ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭХ
СУДАЛГАА ХИЙХ, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
НЭГДСЭН ТАЙЛАН**

**ТЭНГИС-ШИШГЭДИЙН
ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР**

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БҮСИЙН “БИОЛОГИЙН ОЛОН
ЯНЗ БАЙДЛЫН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БҮРДҮҮЛЭХ СУДАЛГАА ХИЙХ, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ” дэд төсөл (№ 16-B005)

Захиалагч:

**Байгаль орчин, аялал жуулчлалын яам
“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд
дасан зохицох” төсөл**

Санхүүжүүлэгч:

Германы Засгийн газар ба KfW хөгжлийн банк

Үндсэн гүйцэтгэгч:

Монголын шувуу судлалын нийгэмлэг

Судалгаанд оролцож, хамтран ажилласан:

**Монгол улсын их сургууль
Шинжлэх ухааны академи
Монголика консалтинг
Тусгай хамгаалалттай газрын захиргаа**

Улаанбаатар 2016

Гарчиг

Тэнгис-Шишгэдийн БЦГ-ын тухай товч танилцуулга.....	5
Судалгааны зорилго.....	6
Талархал	6
НЭГ. СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН.....	7
1.1 Судалгаа гүйцэтгэсэн хугацаа	8
ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
2.1 Тулын судалгааны арга, аргачлал	8
2.2 Халиун бугын судалгааны арга, аргачлал	9
2.3 Хөхвөр олбийн судалгааны арга, аргачлал.....	9
ГУРАВ. СУДАЛГААНЫ ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ХЭМЖЭЭ, ОНЦЛОГ.....	10
ДӨРӨВ. ТҮЛХҮҮР ЗҮЙЛИЙН СУДАЛГАА.....	11
4.1 Тул.....	11
4.2 Халиун буга.....	15
4.3 Хөхвөх олби	21
4.4 Цаа буга	25
ТАВ. ЗҮЙЛИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨНД ЭМЗЭГ БАЙДАЛ.....	29
ЭШ ТАТСАН БҮТЭЭЛ	30
ХАВСРАЛТ ТШ1. Судалгаанд холбогдох гэрэл зураг	31
ХАВСРАЛТ ТШ2. ТЭНГИС-ШИШГЭДИЙН УТХГ-ЫН ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧИД, ШУВУУ, ХӨХТНИЙ ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ	32
ХАВСРАЛТ ТШ3. Тэнгис-Шишгэдийн БЦГ-ын түлхүүр зүйлийн судалгааны замнал ба бүртгэл	47

Товчилсон үгс:

БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БНГ	Байгалийн нөөц газар
БЦГ	Байгалийн цогцолбор газар
ДБХХ	Дэлхийн байгаль хамгаалах холбоо
ДЦГ	Дархан цаазат газар
МУИС	Монгол улсын их сургууль
МШСН	Монголын шувуу судлалын нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНУГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар
ШУА	Шинжлэх ухааны академи
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
ТШБЦГ	Тэнгис-Шишгэдийн байгалийн цогцолбор газар
УТУТХГ	Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар
ТШ	Тэнгис-Шишгэд

ТЭНГИС-ШИШГЭД БЦГ-ЫН ТҮЛХҮҮР ЗҮЙЛ

- Тул
- Халиун буга
- Хөхвөр олби (нэмэлтээр)
- Цаа буга (нэмэлтээр)

Тэнгис-Шишгэд БЦГ-ын тухай товч танилцуулга

Тэнгис-Шишгэд БЦГ нь Алтай, Соёны физик газарзүйн их мужийн төлөөлөл болдог. Онцлог тогтоцтой уулс, гол, нууруудын цогцолбор бүхий биологийн янзын нөөц баялагтай бөгөөд эртний түүх, соёл, өвөрмөц амьдралын хэв маяг үлдэж хоцорсон нутаг юм. Монгол орны хамгийн хойд хязгаар Монгол шарын даваанаас түүхт Тэнгисийн гол эх аван урсаж, Шишгэдийн голд цутгадаг. Хорьдол-Сарьдаг болон Улаан тайгын нурууд, Соёны уулс, Дархадын хотгорын бүх гол горхи, нуурын ус хойд Агийяа уулсын хоорондох ан цав, хагарлыг даган урсаж, алдарт Енисей мөрний эх болдог зэргийг үндэслэн 2011 оны 18-р тогтоолоор байгалийн цогцолборт газрын ангиллаар 867,070 га талбайг улсын тусгай хамгаалалтад авжээ.

Тэнгис-Шишгэд бэлчрээс улсын хил гартал үлэмж усархаг цутгалууд бий болгох учир Шишгэд голын урсац ОХУ-ын Уш-Быльдыр усзүйн харуулын хэмжилтээр 142 м³/сек ба урсацын модуль нь 7.07 л/с км² хүрдэг. Шишгэд голд Улаан Тайга, Зүүн Соёны нуруунаас эх авах Мунгараг, Хөг, Арсай, Хотон, Гуна, Баян, Жаргалант, Шумуулт, Алхан, Шарга, Хармай, Жамс, Жолог, Нуурт Бяран, Их Жамс, Сариг зэрэг олон том, жижиг гол цутгана.

Тэнгис-Шишгэд ай савын БЦГ-т хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн нэн баялаг. Энэ нутгийн гадаргын байдал, ландшафтын онцлогтой уялдан умрын ой тайгын зүйлүүд (хүрэн баавгай, ойн булга, нохой зээх, баданга хүдэр, халиун буга, бор гөрөөс, хандгай, зэрлэг гахай, алтайн чацуулин, улаан ойсог, чандага, асганы огдой, бараан хэрэм), мөн Төв Азийн хээрийн зүйлүүд (шивэр алагдаага, хярс, үнэг, хүрэн үен, дагуур огдой, бор туулай, хэргэлзий огтоно г.м), түүнчлэн өндөр уулын зүйлүүд (янгир, саарал чоно, суусар, булга, цоохор ирвэс, цаа буга, тагийн огдой г.м) харилцан нэвтрэлцэж, зэрэгцэн амьдардаг.

Тайгын ойн хэв шинжид гол төлөв шинэс, шинэс-хушин ой зонхилох бөгөөд ойн доод хил нь 1500-1600 м, дээд хил нь 2200 м өндөрт байх ба түүнээс дээш 2400 м хүртэл цармын тармаг ой үргэлжилнэ. Тэдгээрийн ургамлан нөмрөгт тэрэлжээс гадна *Salix reticulata*, *Bergenia crassifolia*, *Legum palustre*, *Vaccinium uliginogum*, *V. Vitisidaea*, *Empetrum nigrum* зэрэг жинхэнэ тайгын гол төлөв ховор элементүүд үргэлж өндөр арвитай ургах учраас өвслөг, бутлаг ургамлан бүрхэц төдийлөн бага (Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө 2016-2020, 2015).

Судалгааны зорилго

Бидний хээрийн судалгаа Монгол-Германы Засгийн газрын хооронд 2013 онд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд KfW хөгжлийн банкаар дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн дэд төсөл хэрэгжүүлэх Төв, Хангай, Зүүн бүсийн нийт 11 хамгаалалтын захиргаанд харъяалагдах 15 тусгай хамгаалалттай газар (Дорнод Монгол, Зэд Хантай Бүтээлийн нуруу, Онон-Балж, Орхоны Хөндий, Отгонтэнгэр, Тарвагатайн нуруу, Улаан тайга, Хангайн нуруу, Хан Хэнтий, Хустайн нуруу, Горхи-Тэрэлж, Монгол Дагуур, Тосонхулстай, Хорьдол Сарьдаг, Тэнгис Шишгэд)-ын биологийн олон янз байдлын түлхүүр зүйл буюу хамгааллын үнэт (зорилтот) зүйлийг тодорхойлох зорилгоор энэхүү суурь судалгааг гүйцэтгэв.

Тэнгис-Шишгэд БЦГ-т гүйцэтгэсэн энэхүү судалгаа нь 4 түлхүүр зүйл (тул, халиун буга, хөхвөр олби, цаа буга)-ийн тархац, байршил, тоо толгойн өнөөгийн төлөв байдлыг судлан тогтоох, суурь судалгааны материал бүрдүүлэх, мониторинг судалгааны талбай сонгох, арга зүйг системтэй боловсруулах үндсэн зорилготой.

Талархал

Энэхүү судалгааг амжилттай гүйцэтгэхэд чин сэтгэлээсээ тусалж, хээрийн судалгааны багт оролцон ажилласан Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын захиргааны нэр дурдсан дараах хүмүүст гүн талархал илэрхийлье. Үүнд:

- Ж. Төмөрсүх (Улаан тайгын УТХГ-уудын хамгаалалтын захиргааны дарга)
- Ө. Нямгэрэл (Улаан тайгын ДЦГ-ын Ойн судалгаа хариуцсан мэргэжилтэн)
- Г. Даваацэрэн (Улаан тайгын ДЦГ-ын судалгаа хариуцсан мэргэжилтэн)
- Г. Баасан (Улаан тайгын ДЦГ-ын нягтлан бодогч)
- Д. Лхагважав (Улаан тайгын ДЦГ-ын нярав)
- О. Бямбаа (Хорьдол Сарьдагийн ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Д. Ням-Очир (Хорьдол Сарьдагийн ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Б. Далайбаяр (Улаан тайгын ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Б. Болдбаатар (Улаан тайгын ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- С. Ренчиндаваа (Хорьдол Сарьдагийн ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Х. Баярхүү (Тэнгис-Шишгэд БЦГ-ын байгаль хамгаалагч)
- М. Одхүү (Тэнгис-Шишгэд БЦГ-ын байгаль хамгаалагч)

НЭГ. СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1.1 Багийн үндсэн бүрэлдэхүүн:

- Ж.Мөнх-Эрдэнэ (Монголын шувуу судлалын нийгэмлэгийн судлаач, магистрант)
- Б.Оюунтуяа (Монголын шувуу судлалын нийгэмлэгийн судлаач, магистрант)
- Б.Цэвээнпүрэв (Монголика ХХК-ийн судлаач)
- Г.Хүдэрчулуун (МУИС-ийн ШУ-ы сургуулийн Биологийн 4-р түвшний оюутан)
- Г.Батнямсүрэн (Жолооч)

1.2 Байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагчид:

- Ө. Нямгэрэл (Улаан тайгын ДЦГ-ын Ойн судалгаа хариуцсан мэргэжилтэн)
- Б. Далайбаяр (Улаан тайгын ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Б. Болдбаатар (Улаан тайгын ДЦГ-ын байгаль хамгаалагч)
- Х. Баярхүү (Тэнгис-Шишгэд БЦГ-ын байгаль хамгаалагч)
- М. Одхүү (Тэнгис-Шишгэд БЦГ-ын байгаль хамгаалагч)



Зураг ТШ1. Тэнгис-Шишгэд БЦГ-ын тулын судалгаа хийсэн багийн бүрэлдэхүүн. Тэнгис-Шишгэд голын бэлчир. Зүүн гар талаас: Ж.Мөнх-Эрдэнэ (МШСН), Х. Баярхүү (УТУТХГ), Ө. Нямгэрэл (УТУТХГ), Б.Оюунтуяа (МШСН)



Зураг ТШ2. Тэнгис-Шишгэд БЦГ-ын халиун буга, хөхвөр олбийн судалгааг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн. Улаан-Уул сум. Зүүн гар талаас: Б. Далайбаяр (УУТХГ), Г. Хүдэрчулуун (МШСН) Б. Болдбаатар (УУТХГ)

Судалгаа гүйцэтгэсэн хугацаа

Тэнгис-Шишгэд БЦГ-ын нутаг дэвсгэрт тул, халиун буга, хөхвөр олбийн тархац, байршил, тоо толгойн хээрийн судалгааг аргачлалын дагуу морь, машин, завь болон явганаар 600 орчим км замд 2016 оны 8-р сарын 12-аас 8-р сарын 24-ны хооронд гүйцэтгэв.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Тулын судалгааны арга, аргачлал

Цэгэн ажиглалтыг хийхдээ голын хэсгийг өргөн талбайгаар харах боломжтой өндөр эрэг, хадан хясаа болон намхан эрэгтэй хэсэгт загасны хөдөлгөөнийг сайтар ажиглах боломжтой байрлалыг сонгон авч ажиглалт хийсэн боловч гол үертэй, ус өнгөтэй байв. Мөн голын дагуу завиар замналын судалгаа хийсэн боловч усанд загас харагдах боломжгүй байв. Тулын судалгааны арга зүйг Хавсралт ЕБ2-оос үзнэ үү.

2.2 Халиун бугын судалгааны арга, аргачлал

Халиун тархац, байршил, тоо толгой, нягтшилын хээрийн судалгаанд ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж баталсан “Байгалийн амьтан, ургамлын мониторинг судалгааны нэгдсэн арга зүй” (Биологийн хүрээлэн, 2015), Б.М.Житковын нэрэмжит Бүх Оросын агнуурын аж ахуй, үслэг ан судлалын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан “Учёты и ресурсы охотничьих животных России” (Киров-Ижевск, 2009) зэрэг аргачлалуудыг ашиглав. Энэ судалгаанд шугаман замналын арга болон цэгэн ажиглалтын арга гэсэн 2 үндсэн аргыг газар орны нөхцөлд тохируулан хослон хэрэглэв. Шугаман замналын аргыг ялгаатай амьдрах орчин бүрт хэрэглэсэн бөгөөд үүний гол аргачлал нь тодорхой урт, өргөнтэй маршрут хийж, түүний явцад харсан амьтан хүртэлх зай, өнцөг, тоологчийн тухайн агшинд зогсож буй цэгийн солбицол болон бусад мэдээллийг нэг бүрчлэн урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд бичлээ. Харин цэгэн ажиглалтын арга нь тодорхой нэг өндөрлөг харууцтай газрыг сонгоод түүн дээрээ тодорхой хугацаанд сууж дурандах замаар амьтдыг тоолдог арга. Бид Улаан тайгын ДЦГ-ын халиун бугын судалгаанд шугаман замналын болон цэгэн тооллогын аргыг хослуулан хэрэглэж тоо толгой, нягтшилыг тооцов.

Ойн экосистемийн битүү орон зайд байршин амьдардаг туруутан амьтдын тархац, байршил, тоо толгойг тооцон гаргахад тэдгээрийн амьдрах орчиндоо үлдээсэн элдэв ул мөр маш чухал мэдээлэл болж өгдөг. Тиймээс эдгээр амьтдын хувьд дээрх ул мөрөөр нь тухайн амьтны тархац, тоо толгойг тооцоолж гаргадаг нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны арга зүй ч байдаг. Харин энэ удаад бид УТХГ-уудын нутагт судалгаа хийхдээ түүний шинэ ялгадас, шинэ мөр, шинэ хэвтэр зэрэг элдэв ул мөрийн мэдээлэл цуглуулан түүнд задлан шинжилгээ боловсруулалт хийх замаар тэдгээрийн тоо толгойг тооцож гаргасан болно (Хавсралт ЕБ2).

2.3 Хөхвөр олбийн судалгааны арга, аргачлал

Хөхвөр олбийн тархац, байршил, тоо толгой, нягтшилын хээрийн судалгаанд ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж баталсан “Байгалийн амьтан, ургамлын мониторинг судалгааны нэгдсэн арга зүй” (Биологийн хүрээлэн, 2015) арга зүйг баримтлав. Хээрийн судалгаанд шугаман замналын арга болон дээж талбайн 2 аргыг газар орны нөхцөлд тохируулан хэрэглэсэн ба шугаман замналаар олбийн амьдрах орчинд нь тодорхой урт, өргөнтэй маршрут хийж, түүний явцад харсан амьтан хүртэлх зай, өнцөг, тоологчийн тухайн агшинд зогсож буй цэгийн солбицол болон бусад мэдээллийг нэг бүрчлэн урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд тэмдэглэв. Дээж талбайн арга нь ойд 200 м х 200 м талбай сонгож, талбай дахь модыг нэг бүрчлэн шалгаж хүснэгтийн дагуу мэдээллийг тэмдэглэлээ.


Шугаман замналыг мориор, дээж талбайд явганаар судалгаа хийв. Судалгааны явцад олби үүрлэх боломжтой моднуудыг цохиж, модны мөчир, хонгилыг сайн ажиглаж явлаа (Хавсралт ЕБ2).

ГУРАВ. СУДАЛГААНЫ ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ХЭМЖЭЭ, ОНЦЛОГ

Тэнгис-Шишгэд БЦГ нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Умардын дэд их мужийн Тайгын муж, түүний Дорно сибирийн дэд мужийн Хөвсгөлийн тойрогт багтана (Банников, 1954). Энд Соёны нурууны төгсгөл болох далайн түвшнээс дээш 2,500-2,800 м өргөгдсөн өндөр уулс хамрагдах ба хамгийн өндөр оргил нь 3,163 м өндөрт оршино. Зүүн Соёны салбар нуруудаас Шишгэд голын хойт хөндий рүү түрж тогтсон хэдэн нурууд бий. Тэдгээрээс хамгийн том нь Тэнгис голын баруун талаар хойноосоо урагшаа голдочийн дагуу тогтсон 2,400 – 2,800 метр өндөр Их – Агаягийн нуруу юм. Энэ нуруу улсын хилээс эхэлж Шишгэд голын хөндийг огтлон улмаар Доод Тайгасын нуруутай нийлнэ.

Чийг тунадас их, ууршилт бага учир гадаргын усны сүлжээ ихээхэн нягт. Энэ нутагт цэвэр усны томоохон нөөц агуулагддаг бөгөөд манай орны урсац бүрэлдэх “цөм” нутаг болдог онцлогтой. Ялангуяа Дархадын хотгорыг хүрээлэн орших уул, нуруудаас эх авах булаг, шанд, гол горхи нь бүгд Шишгэд голын савд усаа юүлэх учир Монгол улсдаа хамгийн их гадаргын усны нягтшилтай бүс нутагт тооцогдоно. Томоохон голуудад Дэлгэрмөрөн, Шишгэд, Тэнгис зэрэг орно. Өндөр уул нуруу ихтэй учраас ойн ургамалжилтаас гадна өндөр уулын бүлгэмдэл ихээр тархдаг онцлогтой ба уулын тундрын, ойн, уулын нугын зэрэг ургамалжилтын хэд хэдэн хэв шинж зонхилно.

Бид хээрийн судалгааг Тэнгис-Шишгэд голын бэлчир болон баруун тайгаар 18,746 га талбайд хийж гүйцэтгэв (газрын зураг ТШ1).



Газрын зураг ТШ1. Тэнгис-Шишгэд БЦГ-т гүйцэтгэсэн түлхүүр зүйлийн судалгааны замнал

ДӨРӨВ. ТҮЛХҮҮР ЗҮЙЛИЙН СУДАЛГАА

4.1. ТУЛ

Монгол нэр: Тул

Шинжлэх ухааны нэр: *Hucho taimen* /Pallas, 1773/

Англи нэр: Taimen

Онцлог шинж: Бие нь бүдүүн, уртавтар. Мөн хагас сар хэлбэртэй ба хар толбуудтай. Толгой дээр жижиг дугуй толботой. Ам тэгш, том эрүүтэй, тагнай бөх шүдтэй. Хажуу тал зэсэн улаан толботой, өөхий мөнгөлөг цагаан өнгөтэй. Нуруу боровтор бараан, өөхөн сэлүүртэй. Үржлийн үед хэвлий сүүлний сэлүүрүүд улаан ягаан өнгөтэй болдог. Залуу тулын биеийн хажуу 7-10 хар өнгийн хөндлөн судалтай. Хавар 5 сарын эхээр голын цөн түрэх үед хайрган ёроолтой, түргэн урсгалтай хэсэгт түрсээ шахна (Монгол улсын улаан ном, 2013).




Тул.

Хамгааллын статус: ДБХХ-ны Улаан дансанд бүс нутгийн хэмжээнд “Устаж болзошгүй” зэрэглэлээр үнэлэгдсэн. Монгол улсын амьтны тухай хууль (2012), Монгол улсын улаан ном (2013)-д ховор статусаар орсон.


Амьдрах орчин: Хүйтэн устай нуур, ширүүн урсгалтай голын гүнзгий булан тохойн усанд байршина (Баасанжав ба Цэнд-Аюуш, 2001).

Монгол орон дахь тархац: Шишгэд, Хөг, Дэлгэрмөрөн, Эг, Онон, Хэрлэн, Халх, Сэлэнгэ мөрний томхон цутгал голууд, мөн Буйр болон Дархадын хотгорын зарим нуурт тархжээ (Монгол улсын улаан ном, 2013).



Газрын зураг ТШ2. Монгол орон дахь тулын тархац

Тусгай хамгаалалттай газар дахь тархац: Тэнгис-Шишгэд БЦГ-ын хэмжээнд Шишгэд гол түүний томоохон цутгал болох Хөг, Тэнгис болон Дархадын Хотгорын жижиг цутгал гол, нууруудад тархсан (Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө (2016-2020), 2015) (газрын зураг ТШЗ).



Газрын зураг ТШЗ. Тэнгис-Шишгэд БЦГ-ын тулын тархац

Тайлбар: Тэнгис-Шишгэд голын сав дагуу бид дараах цэгт судалгаа гүйцэтгэв. Гол үер ихтэй учир судалгааг өргөн хүрээнд хийхэд хүндрэлтэй байв (хүснэгт ТШ1). Харин гол дагуу завиар шугаман замналаар явахад усан дотор загас ажиглагдаагүй.

Хүснэгт ТШ1. Тэнгис-Шишгэд голын сав дагуу тулын судалгаа хийсэн цэг

Сав газар	Газрын нэр	Солбицол		Тайлбар
		Өргөрөг	Уртраг	
Тэнгис голын сав дагуу	Шивээний ар	51.484731	99.06049	Гол үертэй тул харагдах боломжгүй
Шишгэд голын сав дагуу	Шишгэд Усар ам	51.443392	99.20198	
	Тэнгис-Шишгэд голын бэлчир	51.468942	99.02504	
	Шишгэд Сариг голын бэлчир	51.466992	99.00990	
	Ханагай	51.470200	98.82527	

ТҮЛХҮҮР ЗҮЙЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Амьдрах орчин, тархац, тоо толгой, нягтшилд одоогоор нөлөөлж буй хүчин зүйлс:

Тул загас нь голын усны цэнгэг байдал, байгалийн унаган төрхөөрөө байгааг илэрхийлэгч экосистемийн зохистой байдалд чухал үүрэгтэй. Хулгайн ан, амьдрах орчны доройтлоос шалтгаалан популяцийн тоо толгой цөөрсөн. Сүүлийн жилүүдэд өндөр үнэ төлж тусгай зөвшөөрөлтэй спорт загасчлалын жуулчид их хэмжээгээр зорин ирдэг болсон нь сөргөөр нөлөөлж болзошгүй. Тэнгис-Шишгэд БЦГ-ын хэмжээнд 2011 оноос хойш хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, сумдын байгаль хамгаалагч, нутгийн иргэдтэй хамтран тул загас хамгааллын чиглэлээр ажиллаж байна (Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө (2016-2020), 2015).

Цаашид хамгаалахад шаардлагатай арга хэмжээ:

- 1. Судалгааны чиглэлээр.** Тэнгис-Шишгэд болон түүний цутгал гол, нууруудад тулын үржлийн нутгуудыг тогтоох, мониторинг судалгааг жил бүр хийх шаардлагатай. Судалгаанд тухайн нутгийн иргэд, загас сонирхогч болон хөтөч-тайлбарлагч, жуулчдыг татан оролцуулах нь загасны тархац, улирлын чанартай байршил, үржлийн болон түрс шахах газруудыг тогтоох, чухал амьдрах орчны тухай бодитой мэдээ баримтыг цуглуулах боломжтой.
- 2. Нөөцийг хамгаалах, өсгөх чиглэлээр.** Мониторинг судалгааны үр дүнгээр хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. Үржлийн нутгуудыг тодорхой хугацаагаар тусгайлан хамгаалах, өвлийн ичээ газарт загас бариулахгүй байх, спорт загасчлал болон хулгайн анчдад тавих хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах хэрэгтэй.
- 3. Боловсон хүчэнг бэхжүүлэх чиглэлээр.** Улаантайгын хамгаалалтын захиргаанд ажилладаг дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид нь зэрлэг амьтдын тархац, байршил, тоо толгойн талаар судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнгээр мэдээллийн сан байгуулсан. Нэг зорилгын дор нэгдэж, газар нутгаа сайтар танин мэдэхийн төлөө хичээл зүтгэлтэй ажиллаж буй тэднийг шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр зайлшгүй хангах хэрэгтэй.
- 4. Сургалт, сурталчилгааны чиглэлээр.** ДЦГ-ын байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдэд ургамал, загас, хоёр нутагтан, мөлхөгч, шувуу, хөхтөн зэрэг олон чиглэлээр таньж тодорхойлоход чадваржуулах, мөн судалгааны арга зүйн сургалтуудыг системтэй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай. Мөн хамгаалалтын захиргаанаас отрын малчид, нутгийн иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, танин мэдэхүйн талаар ухуулга, сурталчилгаа сайн хийх нь байгаль хамгаалалд нэн чухал.
- 5. Хамтын ажиллагааны чиглэлээр.** Биологийн олон янз байдлын судалгаа, байгаль хамгааллын талаарх мэдээллийг нутгийн иргэдэд түгээх, БОАЖЯ болон хэрэгжиж буй төслүүд, хамгаалалтын захиргааны хамтын ажиллагааг бэхжүүлж, судлаачдын саналыг менежмент төлөвлөгөө, хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө, судалгааны ажилд тусгахад анхаарах. УТХГ-ын онцлог, биологийн олон янз байдлыг таних гарын авлага хэвлүүлэх нь хамгааллын болон танин мэдэхүйн чухал ач холбогдолтой.
- 6. Аялал жуулчлалын чиглэлээр.** Хөвсгөл аймаг нь аялал жуулчлал харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Тэнгис-Шишгэд БЦГ-т тусгай сонирхлын аялал хөгжүүлэх нь үр дүнтэй. Ялангуяа спорт загасчлалыг зүй зохистой зохион байгуулах хэрэгтэй.

4.2. ХАЛИУН БУГА

Монгол нэр: Халиун буга

Шинжлэх ухааны нэр: *Cervus elaphus* Linnaeus, 1758

Англи нэр: Red deer or Elk

Онцлог шинж. Биеийн зуны өнгө шаргал, бор хүрэн, өвлийн зүс бор саарал. Өвлийн үсэн бүрхүүл 3-4 см урт ширүүн сор үс, өтгөн ноолууртай. Тана тод цайвар шаргал өнгөтэй бөгөөд бараан хүрээтэй. Зоргол нуруугаараа толботой. Намрын гуужилтаар толбо нь аажим арилна. Бие гүйцсэн эр бугын биеийн урт 213-247 см, согооных 193-232 см; эрийн биеийн жин 250-345 кг; сэрвээний өндөр дайрт 142-165 см, согоонд 124-152 см байна. Зөвхөн эр нь эвэртэй. Эврийн урт 1,5 м, далайц 1,3 м хүрнэ. Эврийн жин 6-7 кг орчим. Эрэгчний толгойн яс согооныхоос том. Толгойн яс 3 настайд бүрэн хэлбэржинэ. Нас ахих тутам эвэр уртасч, хүчирхэг болно. Эврийн хөгжил 5-6 настайд гүйцэх бөгөөд 10-12 насны эрэгчин хамгийн хүчирхэг эвэртэй ба үүнээс хойш хөгшрөлтийн шинж илэрнэ. Эврээ хавар 3-4 сард гэж, намар дуудлагын өмнө шинэ эвэр ургаж гүйцнэ. Ороо 9-10 сард орно. Бугын дуудлага нь согооны орооны хугацааг жигдрүүлэх, байршлаа мэдэгдэх, өрсөлдөгчөө тодорхойлох гэх мэт олон талын үүрэгтэй. Хээл тээх хугацаа 230-258 хоног. Согоо 5-7 сард голчлон нэг илий гаргана. Өвлийн байршилд цасан бүрхүүлийн зузаан, хатуурч хунгарлах нь хязгаарлах нөлөөтэй. Цас, мараа, шавар, голын эргийн элсэн дээрх мөрөөр нь танихаас гадна буга элбэг газар модны оройн хэсгийг идсэн, холтсыг хуулсан ул мөр үзэгдэнэ. Зөөлөн хөрсөн дээр гарсан мөр 7 см орчим өргөн. Бугын дуудлага болох газар 1-7 м хүртэл голчтой ухаж, онгичсон газар үүснэ. Баас цилиндр хэлбэртэй, хар өнгөтэй, тэжээлээс шалтгаалан янз бүрийн хэмжээтэй байх бөгөөд 1.5 см диаметртэй (Батсайхан нар, 2014).




Бие гүйцсэн буга.

Экологийн статус: Улирлаас хамааран шилжилт хөдөлгөөн хийдэг. Ичдэггүй зүйл.

Хамгааллын статус: ДБХХ-ны Улаан дансанд олон улсын хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд “Ховордож болзошгүй” зэрэглэлээр үнэлэгдсэн.

Амьдрах орчин: Монгол орны халиун бугын тархац манай орны ойн бүсийн хилтэй яг тохирно. Гэвч улирлаар байршлаа солино. Буга өндөр уулын таг сарьдгийн зооноос голын хөндий татам хүртэлх олон янзын биотопд байршина. Өвөл ба зуны байршил тодорхой ялгарна. Өвөлд алаг өвст энгэр, задгай газар, ойн чөлөө бүхий уулын дунд хэсгийн 1300-2000 м өндөр шинэсэн ой, энгэр суга хавьд, зуны улиралд голын хөндийгөөс таг, сарьдгийн зоо хүртэл голдуу ар хажууг дагаж уулын өндөршлийн хэмжээнд бэлчинэ. Зуны улиралд халуун, ялаа шумуул ихтэй үед таг сарьдаг, хяр дээгүүр бэлчээд өглөө оройн сэрүүнээр голын хөндий рүү бууж мараанд ирэх ба харин бороо хуртай үед ойд голдуу байршина. Харин хаврын улиралд эвэр нөмөрдүү газарт шаваг, нахиалж яргуй цухуйх үеэр ногоо дагаж ойн хаялга, чөлөө, энгэр, бэлээр бэлчинэ. Энэ үед буга задгай орон зайд ил гарах нь элбэг тул энэ үед тоо толгойг нарийвчлан бүртгэх боломж илүү байдаг. Бугын улирлаар ингэж байршлаа өөрчлөх хандлагыг дараагийн судалгаанд анхаарч хээрийн судалгааны хугацаагаа товллох нь зүйтэй.


Монгол орон дахь тархац: Монгол орны ой модтой бүх нутгийн хэмжээнд буюу Монгол–Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Хянганы салбар уулсын тайга, ойт хээр, мөн хээрийн бүсийн зарим нутгийг хамарч бараг 500 мянган ам км нутгийн хүрээнд буюу 14 аймгийн 140 гаруй сумын дэвсгэр нутагт аль нэг хэмжээгээр тархан нутагладаг болохыг тогтоожээ (Монгол орны ойн туруутны популяцийн үнэлгээний тайлан, 2010).



Газрын зураг ТШ4. Халиун бугын Монгол орон дахь тархац

Тусгай хамгаалалттай газар дахь тархац: Жолог, Жошим, Бус, Гадар өөс, Шишгэдийн адаг, Жамс, Хойд, Урд агай, Бяран, Баруун, Зүүн тайга зэрэг газруудад голлон тархсан (Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөө (2016-2020), 2015).

Бид халиун бугын тархац нутгийн зураглалыг өөрсдийн судалгааны бүртгэл, ул мөр, байгаль хамгаалагчдын аман мэдээ, тухайн хамгаалалтын захиргааны 2016 оны мониторинг судалгааны үед бүртгэсэн цэг болон амьдрах орчинд тулгуурлан зураглав (газрын зураг ТШ5).



Газрын зураг ТШ5. Тэнгис-Шишгэд БЦГ-ын халиун бугын тархац

Тархац нутгийн хэмжээ: Халиун буга өтгөн хөвч тайгаас илүү энгэртээ ойгүй, уулсын сийрэг шинэсэн ой, шинэс зонхилсон холимог ой, шинэс-хушин ой, хус-улиангарт дан навчит ой, голын шугуй зэрэг задгай газар элбэгтэй амьдрах орчныг шүтэн амьдардаг бөгөөд Тэнгис-Шишгэд БЦГ орчны бүсийг багтаагаад нийт 487,702.4 га талбайд тархана.

Тоо толгой: Монгол орны халиун бугын хувьд ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судлаачдын судалгаагаар 1986 онд 115,000 км² нутагт 130,000 бодгаль байсан (Дуламцэрэн нар, 1989) бол 2004 онд 15 аймагт 8,000-10,000 бодгаль болж сүүлийн 18 жилийн дотор 92 хувь цөөрсөн. БОАЖЯ-аас зохион байгуулсан ШУА-ийн Биологийн хүрээлэн болон бусад их дээд сургуулийн судлаачид хамтран 2010 онд хийсэн Монгол орны ойн туруутны нөөцийн үнэлгээгээр Монгол орны 14 аймгийн нутгийг хамарсан нийт 124,612 км² нутагт 16,482 бодгаль бий гэж тооцоолжээ (Монгол орны ойн туруутны популяцийн үнэлгээ, 2010).

Хөвсгөл орчимд хамгийн их нягтаршилтай Шарга, Хөг, Буурал голын ойт хөндий, Хошт хэм, Хосдог, Сул орчмоор 1000 га талбайд 4-7 буга тэмдэглэсэн ба аймгийн хэмжээнд бугын дундаж нягтаршилт бүх тархац нутгийн 1000 га тутамд 1-2 буга тохиолдоно хэмээн судлаачид тэмдэглэжээ (Базардорж ба Сүхбат, 1984). Тэнгис-Шишгэд халиун бугын судалгааны мэдээ баримт өнөө ч ховор байна.

Бидний судалгааны дүнгээс үзвэл нийт 10 бодгалиас буга 3, согоо 6, илий 1 байна. Тэнгис-Шишгэд БЦГ-т халиун буга 487,702.4 га талбайд тархах бөгөөд нийт популяцийн хэмжээ 167.69 бодгаль (стандарт алдаа ± 86.3 , min 0, max. 1438.1) гэж тооцоолов (хүснэгт ТШ2).

Нас, хүйсийн бүтэц: Бидний судалгааны туршид нийт 10 бодгаль тэмдэглэгдсэнээс буга 3 (30%), согоо 6 (60%), төл 1 (10%) бодгаль бүртгэгдэв. Насны бүтцийн хувьд төл 1 (10%), 2-3 насны залуу 3 (30%), бие гүйцсэн 6 (60%) бодгаль байв (график ХС1).




График ХС1. Халиун бугын сүргийн нас, хүйсийн бүтэц

Нягтшил: Тус ДЦГ-т халиун бугын судалгааг нийт 18,746 га талбай нутгийг хамруулан хийсэн бөгөөд 1000 га дахь нягтшил 0.34 бодгаль, нийт популяцийн хэмжээ 167.69 ± 86.3 бодгаль гэж бид тооцоолов (хүснэгт ТШ2). Гэвч энэхүү нэг удаагийн, богино хугацаат судалгааны өгөгдлөөр нийт популяцийн тоо толгойг үнэлэх нь учир дутагдалтай.

Хүснэгт ХС2. Тэнгис-Шишгэд БЦГ-ын халиун бугын популяцийн тоо толгой, нягтшилын судалгааны дүн

№	Талбайн дугаар	Газрын нэр	Огноо	Бүртгэсэн бодгалийн тоо	Хүйс		Нас				Судалгааны талбайн хэмжээ (га)	1000 га дахь нягтшил	Тархац нутгийн хэмжээ (га)	Нийт тоо толгой (нөөц)
					Эр	Эм	Төл	Залуу	Бие гүйцсэн	Тодорхойгүй				
1	ХӨУЛ-VP001	Соёо	2016.08.14								1963	0.00	487702.4	0.00
2	ХӨУЛ-VP002	Мөлхдөгүй	2016.08.14								1017	0.00	487702.4	0.00
3	ХӨУЛ-VP003	Мөлхдөгүй	2016.08.15								803.8	0.00	487702.4	0.00
4	ХӨУЛ-VP004	Ногоон гол	2016.08.15	2		2			2		1963	1.02	487702.4	497.02
5	ХӨУЛ-VP005	Ногоон гол	2016.08.16								706.5	0.00	487702.4	0.00
6	ХӨУЛ-VP006	Ногоон гол	2016.08.16	3	3				3		1017	2.95	487702.4	1438.14
7	ХӨУЛ-VP007	Жолгын хүрэн толгой	2016.08.18								1963	0.00	487702.4	0.00
8	ХӨУЛ-VP008	Хэнзийн боом	2016.08.18	1		1		1			3847	0.26	487702.4	126.79
9	ХӨУЛ-VP009	Жолгын бэлчир	2016.08.19	2		2		2			2123	0.94	487702.4	459.52
10	ХӨУЛ-VP010	Жолгын бэлчир	2016.08.19	2		1	1		1		1963	1.02	487702.4	497.02
11	ХӨУЛ-LT001	Цагаанбэлчир	2016.08.14								480	0.00	487702.4	0.00
12	ХӨУЛ-LT002	Мэнгэ булаг	2016.08.14								400	0.00	487702.4	0.00
13	ХӨУЛ-LT003	Устын голын эх	2016.08.14								100	0.00	487702.4	0.00
14	ХӨУЛ-LT004	Мөлхдөгүй	2016.08.14								120	0.00	487702.4	0.00
15	ХӨУЛ-LT005	Хүгийн сайр	2016.08.15								135	0.00	487702.4	0.00
16	ХӨУЛ-LT006	Ногоон гол	2016.08.16								80	0.00	487702.4	0.00
17	ХӨУЛ-LT007	Хайрлаг	2016.08.17								32	0.00	487702.4	0.00
18	ХӨУЛ-LT008	Жолгын бэлчир	2016.08.17								35	0.00	487702.4	0.00
Нийт дүн				10	3	6	1	3	6	0	18746	0.3438	487702.4	167.69

ХАЛИУН БУГЫН ТАРХАЦ, БАЙРШИЛ, ТОО ТОЛГОЙД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Амьдрах орчин, тархац, тоо толгой, нягтшилд одоогоор нөлөөлж буй хүчин зүйлс:

Бугын байршдаг нутагт хүн, малын нөлөөлөл бага. Ойн түймэрт дунд зэрэг өртдөг. Бугын эвэр, чив, засаа зэрэг эрхтэн худалдаалах, мах бэлтгэх зорилготой хулгайн ан агнуур ихтэй. Нутгийн иргэд, байгаль хамгаалагчдын аман мэдээгээр бугын хос эвэр 7-8 кг жинтэй бөгөөд 1 кг нь 30 орчим мянгөн төгрөг хүрдэг. Шинэ эвэр үүнээс ч үнэтэй.

Халиун бугын тархац, байршилд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор бий болж буй гэнэтийн ган, зуд зэрэг байгалийн хүчин зүйлс ч зохих хэмжээгээр нөлөөлж буйг үгүйсгэх аргагүй. Мөн алт, хаш олборлолт, ой модны хууль бус ашиглалт, самар жимс түүх зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж байна.

Цаашид хамгаалахад шаардлагатай арга хэмжээ, санал, зөвлөмж

Тэнгис-Шишгэд БЦГ-ын нутаг дэвсгэрт тархсан халиун бугыг хамгаалахын тулд гүйцэтгэх шаардлагатай үйл ажиллагаануудыг дурьдвал:

1. Судалгааны чиглэлээр. Энэ бүс нутгийн бугын тархац, байршил, тоо толгойн мониторинг судалгааг жил бүр тодорхой хугацаанд хийхээс гадна 3 жил тутамд тоо толгойн судалгааг нарийвчлан хийж популяцийн өсөлтийн хандлагыг тодорхойлж байх нь чухал. Түүнчлэн жил бүрийн хаварт нутгийн ард иргэдийн цуглуулсан эврийн тоонд анализ хийх замаар бугын тоо толгой, тархац байршлын талаар өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулж судалгаа хийх боломжтой.

2. Халиун бугын нөөцийг хамгаалах, өсгөх чиглэлээр. Хавар, зун, намар, өвлийн байршлыг тогтоосны үндсэн дээр хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх. Бугын хууль бус агнуур орон нутагт тасрахгүй байгаа тухай иргэдийн мэдээлэл бий. Хууль бус агнуураар ашиг олох явдлыг зогсоохын тулд нутгийн иргэдээс мэдээллийг худалдан авах замаар энэ үйл ажиллагааг таслан зогсоох боломжтой. Бугын амьдрах орчныг айл малаар шахахгүй байх, жуулчдын явах замыг тодорхой тогтоож өгөх, тэмдэгжүүлэх шаардлагатай байна. Орон нутгийн иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, танин мэдэхүйн талаар сайтар ухуулж, сурталчлах нь эерэгээр нөлөөлнө. Байгаль хамгааллын нөхөрлөл байгуулж ажиллах нь мөн үр дүнтэй арга.

3. Боловсон хүчэнг бэхжүүлэх чиглэлээр. Улаантайгын хамгаалалтын захиргаанд ажилладаг дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид нь зэрлэг амьтдын тархац, байршил, тоо толгойн талаар судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнгээр мэдээллийн сан байгуулсан. Нэг зорилгын дор нэгдэж, газар нутгаа сайтар танин мэдэхийн төлөө хичээл зүтгэлтэй ажиллаж буй тэднийг шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр зайлшгүй хангах хэрэгтэй.

4. Сургалт, сурталчилгааны чиглэлээр. ДЦГ-ын байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдэд ургамал, загас, хоёр нутагтан, мөлхөгч, шувуу, хөхтөн зэрэг олон чиглэлээр зүйлийг таних, тодорхойлоход чадваржуулах, мөн судалгааны арга зүйн сургалтыг системтэй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай. Мөн хамгаалалтын захиргаанаас отрын малчид, нутгийн иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, танин мэдэхүйн талаар ухуулга, сурталчилгаа сайн хийх нь байгаль хамгаалалд нэн чухал.

5. Хамтын ажиллагааны чиглэлээр. Биологийн олон янз байдлын судалгаа, байгаль хамгааллын чиглэлийн мэдээллийг нутгийн иргэдэд түгээх, БОАЖЯ болон хэрэгжиж буй төслүүд, хамгаалалтын захиргааны хамтын ажиллагааг бэхжүүлж, судлаачдын саналыг менежмент төлөвлөгөө, хамгаалал, судалгааны ажилд тусгах зэргийг анхаарах нь зүйтэй.

6. Аялал жуулчлалын чиглэлээр. Хөвсгөл аймаг нь аялал жуулчлал харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Тэнгис-Шишгэд БЦГ-т тусгай сонирхлын аялал хөгжүүлэх нь үр дүнтэй. Ялангуяа спорт загасчлалыг зүй зохистой зохион байгуулах хэрэгтэй.

4.3. ХӨХВӨР ОЛБИ

Монгол нэр: Хөхвөр олби

Шинжлэх ухааны нэр: *Pteromys volans* (Linnaeus, 1758) (*Pteromys ognevi/ russicus sibiricus*)

Англи нэр: Siberian Flying Squirrel (Russian Flying Squirrel)

Онцлог шинж: Зөөлөн ноолуур бүхий сахлаг үстэй. Биеийн галбир төрх хэрэмтэй төстэй. Биеийн урт 130-205 мм, сүүлний урт 90-140 мм, тавхайн урт 30-39 мм, биеийн жин 90-170 гр. Биеийн хажуугаар хойд, өмнөд мөчдийг холбосон сул арьсан унжлагатай. Зоо нуруу мөнгөлөг саарал, хэвлийн цайвар. Сүүл саглагар, дээд тал нь улбар саарал. Чих хулгар үзүүртээ үсгүй (Батсайхан нар, 2014).




Хөхвөр олби.

Экологийн статус: Ичдэггүй.

Хамгааллын статус: ДБХХ-ны Улаан дансанд олон улсын хэмжээнд “Ховордож болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “Мэдээлэл дутмаг” зэрэглэлээр үнэлэгдсэн.


Амьдрах орчин: Хуш-шинэсэн тайга, шинэсэн ой, хус, улиангарт холимог ой

Монгол орон дахь тархац: Хэнтий, Хөвсгөлийн тайга, Хангай, Монгол Алтай, Их хянганы уулархаг ойгоор нэг зүйлийн олби тархана (Шагдарсүрэн нар, 1972).



Газрын зураг ТШ6. Хөхвөр олбийн Монгол орон дахь тархац. [Зураг солих](#)

Тусгай хамгаалалттай газар дахь тархац: Тэнгис-Шишгэд БЦГ-ын ойн сан бүхий ихэнх талбайд тархах боломжтой гэж үзэн тархцын зургийг амьдрах орчноор зураглав (газрын зураг ТШ7).



Газрын зураг ТШ7. Тэнгис-Шишгэд БЦГ дахь хөхвөр олбийн тархац

Тархац нутгийн хэмжээ: Хөхвөр олби нь Тэнгис-Шишгэд БЦГ-т нийт 474,340 га талбайд тархах боломжтой.

Тайлбар: Олби байрших боломжтой амьдрах орчинд шугаман замнал болон дээж талбайн судалгааны аргаар 397.5 га талбайг хамруулан судалгаа хийсэн боловч нэг ч бодгаль, ул мөр илрүүлсэнгүй (хүснэгт ТШЗ). Судалгааны явцад олби үүрлэх боломжтой моддыг цохиж, модны мөчир, хонгилыг сайн ажиглав. Байгаль хамгаалагч, нутгийн иргэдийн аман мэдээгээр зун харагддаггүй ба өвөл их харагддаг, цасан дээр гарсан ул мөр элбэг тааралддаг. Мөн байгаль хамгаалагчдын 2016 оны 1, 2-р сард үүрийг нь олсон цэгүүд (N51°14'31.1" E098°26'36.8", N50°59'49.9" E098°53'19.1", N51°12'11.2" E098°23'43.0")-ийн ойролцоох талбай болон үүрэнд харагдаагүй.

Хүснэгт ТШЗ. Тэнгис-Шишгэд БЦГ -ын Хөхвөр олбийн судалгаа хийсэн талбай

№	Судалгааны талбайн дугаар	Солбицол	Талбайн хэмжээ	Тайлбар
1	ХӨУЛ-VP001	50°59'17.7", 099°03'54.6"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
2	ХӨУЛ-VP002	51°10'19.3", 098°47'50.7"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
3	ХӨУЛ-VP003	51°10'05.8", 098°47'42.9"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
4	ХӨУЛ-VP004	51°11'06.8", 098°36'26.1"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
5	ХӨУЛ-VP005	51°11'17.8", 098°34'33.1"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
6	ХӨУЛ-VP006	51°12'08.1", 098°32'25.1"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
7	ХӨУЛ-VP007	51°14'33.4", 098°26'46.3"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
8	ХӨУЛ-VP008	51°14'13.2", 098°25'37.9"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
9	ХӨУЛ-VP009	51°14'09.7", 098°26'36.9"	200 м x 200 м	Олби бүртгэгдээгүй
10	ХӨУЛ-LT001	Эхлэлийн цэг 50°59'17.7", 099°03'54.6"	8,000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°05'33.1", 98°58'26.3"		
11	ХӨУЛ-LT002	Эхлэлийн цэг 51°05'33.1", 098°58'26.3"	12000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°08'13.5", 98°55'03.9"		
12	ХӨУЛ-LT003	Эхлэлийн цэг 51°08'13.5", 98°55'03.9"	20000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°10'02.2", 98°52'11.2"		
13	ХӨУЛ-LT004	Эхлэлийн цэг 51°10'02.2", 98°52'11.2"	4000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°10'18.7", 98°47'50.3"		
14	ХӨУЛ-LT005	Эхлэлийн цэг 51°10'18.7", 98°47'50.3"	4000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°11'17.9", 98°36'19.2"		
15	ХӨУЛ-LT006	Эхлэлийн цэг 51°11'17.9", 98°36'19.2"	13500 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°10'56.5", 98°35'56.1"		
16	ХӨУЛ-LT007	Эхлэлийн цэг 51°10'56.5", 98°35'56.1"	10000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°12'36.8", 98°30'27.9"		
17	ХӨУЛ-LT008	Эхлэлийн цэг 51°12'36.8", 98°30'27.9"	8000 м x 50 м	Олби бүртгэгдээгүй
		Төгсгөлийн цэг 51°14'09.7", 98°26'36.9"		
Нийт			3,975,000 м ²	

ХӨХВӨР ОЛБИЙН ТАРХАЦ, БАЙРШИЛ, ТОО ТОЛГОЙД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ**Амьдрах орчин, тархац, тоо толгой, нягтшилд одоогоор нөлөөлж буй хүчин зүйлс:**

Хөхвөр олби нь ой бүхий нутагт байршин амьдардаг учраас амьдрах орчинд ойн түймэр, мод бэлтгэл ихээхэн нөлөөлдөг. Олбийг энэ нутагт агнадаггүй ба Д.Базардорж, Х.Сүхбат нар (1984)-ын бүтээлд Хөвсгөл аймагт олбийн тоо толгой цөөн, нөөц багатай учир агнаж ашиглах бололцоогүй хэмээжээ.

Цаашид хамгаалахад шаардлагатай арга хэмжээ, санал, зөвлөмж

1. Судалгааны чиглэлээр. Улаан тайгын ДЦГ болон Монгол орны хөхвөр олбийн тоо толгой, нягтшлын талаар судалгааны мэдээ материал хомс бөгөөд зарим бүтээлд хавсарга байдлаар дурьджээ. Иймээс энэ бүс нутагт олбийн судалгааг цас орсны дараа гүйцэтгэвэл илүү үр дүнтэй.

2. Нөөцийг хамгаалах, өсгөх чиглэлээр. Мониторинг судалгааны үр дүнгээр хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. Ойн түймэр, мод бэлтгэл, самар, жимс түүх иргэдэд хяналт тавих.

3. Боловсон хүчэнг бэхжүүлэх чиглэлээр. Улаантайгын хамгаалалтын захиргаанд ажилладаг дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид нь зэрлэг амьтдын тархац, байршил, тоо толгойн талаар судалгааны ажил гүйцэтгэж, үр дүнгээр мэдээллийн сан байгуулсан. Нэг зорилгын дор нэгдэж, газар нутгаа сайтар танин мэдэхийн төлөө хичээл зүтгэлтэй ажиллаж буй тэднийг шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр зайлшгүй хангах хэрэгтэй.

4. Сургалт, сурталчилгааны чиглэлээр. ДЦГ-ын байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдэд ургамал, загас, хоёр нутагтан, мөлхөгч, шувуу, хөхтөн зэрэг олон чиглэлээр зүйлийг таних, тодорхойлоход чадваржуулах, мөн судалгааны арга зүйн сургалтыг системтэй зохион байгуулах зайлшгүй шаардлагатай. Мөн хамгаалалтын захиргаанаас отрын малчид, нутгийн иргэдэд байгаль орчны хууль тогтоомж, танин мэдэхүйн талаар ухуулга, сурталчилгаа сайн хийх нь байгаль хамгаалалд нэн чухал.

5. Хамтын ажиллагааны чиглэлээр. Биологийн олон янз байдлын судалгаа, байгаль хамгаалалын чиглэлийн мэдээллийг нутгийн иргэдэд түгээх, БОАЖЯ болон хэрэгжиж буй төслүүд, хамгаалалтын захиргааны хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрдэмтэд, судлаачдын саналыг менежмент төлөвлөгөө, хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөө, судалгааны ажилд тусгахад анхаарах. УТХГ-ын онцлог, биологийн олон янз байдлыг таних гарын авлага хэвлүүлэх нь хамгааллын болон танин мэдэхүйн чухал ач холбогдолтой.

6. Аялал жуулчлалын чиглэлээр. Хөвсгөл аймаг нь аялал жуулчлал харьцангуй сайн хөгжсөн бөгөөд Тэнгис-Шишгэд БЦГ-т тусгай сонирхлын аялал хөгжүүлэх нь үр дүнтэй. Ялангуяа спорт загасчлалыг зүй зохистой зохион байгуулах хэрэгтэй.

4.4. ЦАА БУГА

Монгол нэр: Цаа буга (Цаа буга)

Шинжлэх ухааны нэр: *Rangifer tarandus* (Linnaeus, 1758)

Англи нэр: Reindeer (Caribou)


Онцлог шинж: Бие урт, мөч богино. Өнгө зүсний хувьд хүйсийн ялгаа илрэхгүй боловч бодгаль, улирал, газарзүйн байрлалаас хамаарсан ялгаа ажиглагдана. Өвлийн зүс цайвар саарал, зуных буурал. Биеийн урт этэрт 191-203 см, манжигт 108-114 см. Манжиг, этэр хоёулаа эвэртэй. Хүзүү урт, чих жижгэвтэр, үзүүр мохоодуу. Этэр, манжиг арагш дээш чиглээд үзүүр нь урагш эргэн дугуйрсан олон салаа, хавтгайдуу эвэртэй. Манжгийн эвэр этэрхийнээс бага, цөөн салаатай (Батсайхан нар, 2014).

Экологийн статус: Улирлын шилжилт хийнэ. Ичдэггүй.

Хамгааллын статус: ДБХХ-ны Улаан дансны үнэлгээгээр олон улсын хэмжээнд “Анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” зэрэглэлээр үнэлэгдсэн. Монгол улсын амьтны тухай хууль (2012), Монгол улсын улаан ном (2013)-д нэн ховор статусаар орсон.


Амьдрах орчин: Цаа бугын үндсэн амьдрах орчин нь хаг, хөвд бүхий бэлчээртэй, ян сарьдаг, тайгын бүсүүд орно. Тайгын бүс нь далайн түвшнээс 2500-3500 м өндөрт өргөгдөж модгүй, хяр, таг бүхий ян тайга болж, мөнх цас ирмэглэн хунгарласан байх ба жалга, хоолой, хөндий эхүүдэд мөнх мөсөн тошингууд гялалзаж түүнээс тайгын гол горхиуд эх аван урсана. Цаа буга нь өндөр уулын тайга, тагийн бүсийн амьтан. Зун нүцгэн царам, сарьдгийн зоонд бэлчин ногоон ургамлаар хооллох ба өвөл цас их орох үед цармаас бууж хушин тайгын дээд хэсэг, торлог, давжаа хус, хуштай орчинд бэлчинэ (Дуламцэрэн, 1970).

Монгол орон дахь тархац: Цаа буга нь хойд өргөргийн 50⁰ хүртэл урагш Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хөг, Тунай голын эх, Улаан тайгын нуруу, Мөрөнгийн эх, Ренчинлхүмбэ сумын Тэнгэс, Шарга голын эх, Бяранга, Хуулгын нуруу, Хөвсгөл нуурын зүүн хэсэгт Хэвэн, Жодог, Залуу үүр голын эхний ян сарьдгийн тайга зэрэг газруудаар байршиж, дэлхийн цаа бугын тархцын хамгийн өмнөд хязгаар нь болдог (Банников, 1954; Дуламцэрэн, 1970).



Газрын зураг ТШ8. Цаа бугын Монгол орон дахь тархац

Тусгай хамгаалалттай газар дахь тархац: Тэнгис-Шишгэд БЦГ-ын Монгол Оросын хил дагуух нутгаар өвөл голдуу орж ирдэг ба бид тархцын зургийг байгаль хамгаалагчид, нутгийн иргэд, өмнө нь хийгдсэн судалгааны мэдээ, материалд үндэслэн зураглав (газрын зураг ТШ9).



Газрын зураг ТШ9. Тэнгис-Шишгэд БЦГ дахь цаа бугын тархац

Тоо толгой: Цаа бугын тоо толгой, тархац, байршлын талаар нутгийн анчид, хилийн цэргийнхэн, байгаль хамгаалагч нараас авсан аман мэдээ, өөрсдийн судалгааны мэдээ хэрэглэхүүнд тулгуурлан тоймлон авч үзвэл монгол орны хэмжээнд Хөвсгөлийн хил орчмын уулс, тухайлбал, Улаан тайгаас зүүн тийш Хар Бяран, Жосим, Тэнгис орчимд нийтдээ 60-80 орчим цаа буга тодорхой хугацаанд байршдаг. Харин Шаргын голын эх, Их бүргэдтэй, Нарийн Хороо талд 15-20 орчим бодгальтай сүрэг тогтмол байршдаг байна. 2009 оноос эхлэн цуглуулсан мэдээ баримтаас үзэхэд Хөвсгөл нуурын зүүн хэсэгт, тухайлбал, Нарийн Ханхын голын эх- Эрээн тайга орчимд 20 орчим бодгаль, Хэвэнгийн эх, Залуу үүрийн эх орчимд нийтдээ 60 орчим бодгаль, Саравслаг талдаа цөөхөн тооны бодгаль нүүдлийн байдалтай байршдаг (Монгол орны цаа бугын биологийн нөөц, тархцын судалгааны тайлан, 2012).

Тархац нутгийн хэмжээ: Тэнгис-Шишгэд БЦГ-т 287,072 га талбайд байршин амьдрах боломжтой.

Тайлбар: Цаа буга нь Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, Цагааннуур, Ханх, Цагаан-Үүр сумдын хойд хэсгийн өндөр уул, сарьдгуудаар зөвхөн өвлийн улиралд голлон байршиж байгаад зуны улиралд хил даван нүүдэллэдэг (монгол орны цаа бугын биологийн нөөц, тархцын судалгааны тайлан, 2012). Байгаль хамгаалагчид, нутгийн иргэдийн аман мэдээгээр зөвхөн өвөл орж ирдэг ба зун, намрын улиралд судалгаа хийхэд тохиромжгүй 2 сарын хугацаа шаардлагатай.

ЦАА БУГЫН ТАРХАЦ, БАЙРШИЛ, ТОО ТОЛГОЙД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Амьдрах орчин, тархац, тоо толгой, нягтшилд одоогоор нөлөөлж буй хүчин зүйлс:

Цаа бугын тоо толгойн байдал 1960-аад оны үед одоогийнхтой харьцуулахад нилээд их, тархац нутаг нь харьцангуй өргөн байжээ. 1980-аад оны үед зэрлэг цаан тоо толгой эрс цөөрч, тархац нутаг багассан шалтгаан нь махчин амьтад, хулгайн ангийн нөлөө их байсантай холбоотой (Базардорж ба Сүхбат, 1984).

